



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/142

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 3 дугаар хэсгийн 3.1.3, 3.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Ард Аюушийн өргөн чөлөөнд, орон сууцны хороолол дотор байгуулах “Ойн төгөл”-д тарих мод, сөөг нийлүүлэх, том оврын нарс модыг бордох бордоог нийлүүлэх нийлүүлэгчдийг болон оршуулгын газрыг ойжуулах, ногоон байгууламжийн чиглэлээр хийгдэж байгаа ажлыг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Мод, сөөг, бордоо худалдан авах, оршуулгын газрыг ойжуулах, ногоон байгууламжийн ажлыг олон нийтэд сурталчлах ажилд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Мод, сөөг, бордоо нийлүүлэх нийлүүлэгч болон оршуулгын газрыг ойжуулах, хэвлэл мэдээллээр сурталчилах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн  
А/НЗ дугаар тушаалын бүтэц хавсралт



## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

|                       |                     |   |
|-----------------------|---------------------|---|
| Үнэлгээний дарга :    | хорооны Г.Ууганбаяр | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга   |
| Гишүүд:               | Д.Сүхбат            | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн   |
|                       | Д.Нааяа             | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн   |
|                       | Т.Мөнхнасан         | Улаанбаатар хот. Сүхбаатар дүүргийн 3-р хороо. 24-р байр. 39 тоотод оршин суугч иргэн. /зөвшилцсөнөөр   |
| Нарийн бичгийн дарга: | Л.Баатарцогт        | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн арчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн |

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн  
 А/112 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



МОД, СӨӨГ, БОРДОО ХУДАЛДАН АВАХ,  
 ОРШУУЛГЫН ГАЗРЫГ ОЙЖУУЛАХ, ХЭВЛЭЛ,  
 МЭДЭЭЛЛЭЭР СУРТАЛЧИЛАХ АЖИЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ

| Д.Д | Зардлын нэр төрөл  | Төсөв<br>/ сая төгрөг/                       |
|-----|--|--|
| 1.  | Гацуур тарих, хүрэн навчит монос, шар навчит хайлаас худалдан авах зардал- Үүнд:<br>а/. Ард Аюушийн өр.чөлөө-1-р хэсэгт гацуур тарих, арчлах<br>б/. Ард Аюушийн өр.чөлөө - 2-р хэсэг гацуур тарих, арчлах<br>в/. АрдАюушийн өр.чөлөө – 3-р хэсэг гацуур тарих,арчлах<br>г./ Сүхбаатар, Баянзүрх, Хан-уул дүүрэгт “Ойн төгөл”-д тарих хүрэн навчит монос худалдан авах<br>д/. Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт “ойн төгөл”-д тарих хүрэн навчит монос худалдан авах<br>е/. 6 дүүрэгт байгуулах “Ойн төгөл”-д тарих шар навчит хайлаас худалдан авах | 80.0<br>70.0<br>75.0<br>44.0<br>40.0<br>28.0 |
| 2.  | Бордоо худалдан авах зардал<br>Доломит бордоо /цагаан гантиг/ авах   | 10.0   |
| 3.  | Оршуулгын газрыг ойжуулах зардал /бортоготой хайлаас/  | 8.1  |
| 4.  | Ногоон байгууламжийн ажлыг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах, гарын авлага ном гаргах,<br>Үүнд: а/. Ногоон байгууламжийн чиглэлээр хийж буй ажлыг сурталчлах<br>б/. Мод, сөөг тарих, арчлах гарын авлага ном гаргах<br>в/. Хотын ногоон байгууламжийн талаархи шторк бэлдэх<br>г/.Тохижилтын чиглэлээр хийж буй ажлыг сурталчлах   | 9.5<br>2.0<br>2.0<br>8.5                     |
|     | <b>ДҮН</b>   | <b>377.1</b>                                 |